

# Мөнгө

Ноён  $X$  хадгламж зээлийн хоршоогоо дампуурахыг урьдчилан харж чадсан тул бүх мөнгөө аваад Швейцарь улс руу гарчээ. Тэнд очоод зочид буудлын өрөөн дотроо өөрийн бүх мөнгөн дэвсгэртүүдээ асгасанд өрөөний шалыг дүүргэж орхисон байна. Ингээд тэр өөрийн хөрөнгөндөө эмх журам оруулахаар шийджээ. Юуны өмнө тэрээр өмнөө овоолсон мөнгөн дотор Чингис хааны зурагтай нэг дэвсгэрт маш олон тоогоор байгааг анзаарсан байна. Уг дэвсгэртийн тоо нь бүх дэвсгэртүүдийн нийт тооны хагасаас илүү байжээ. Энэ дэвсгэртүүдийг ялгаж чөмөдэнд хийвэл ноён  $X$ -ийн өрөө арай эмх замбараатай болох юм. Түүнд энэ дэвсгэрт нь хэдэн төгрөгийн дэвсгэрт байсныг олох програм зохио.

## Input

Эхний мөрөнд бүх дэвсгэртүүдийн нийт тоо болох  $N$  ( $1 \leq N \leq 500000$ ) натурал тоо өгөгдөнө. Дараагийн  $N$  мөрөнд өрөөний шалан дээр байгаа мөнгө бүрийн хэдэн төгрөгтэй тэнцэхийг илэрхийлэх  $N$  ширхэг натурал тоо өгөгдөнө. Эдгээр тоонууд нь  $10^9$  – ээс хэтрэхгүй натурал тоонууд байна.

## Output

Олох ёстой дэвсгэрт нь хэдэн төгрөгтэй тэнцэж байгааг илэрхийлэх нэг натурал тоог гаргана

## Example

**Input:**

```
9
10000
500
500
500
50
500
100000
50000
500
```

**Output:**

```
500
```